

## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2026/083/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="mailto:www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a>	Дарга, тэргүүлэх аудитор: Б.Батмөнх Утас: 7036-3040 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
Сүхбаатар сум 2026 он	Ахлах аудитор: Ц.Отгонбаяр Утас: 7036-3036 Цахим хаяг: Otgonbayarts@audit.gov.mn
	Аудитор: Ц.Уртнасан Утас: 7036-2442 Цахим хаяг: urtaa6969@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЖАВХЛАНТ  
СУМЫН 1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ С.ОЮУНЧИМЭГ ТАНАА

2026.02.25 № СЭМ-2026/025/НА-СЭМ-143  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т  
**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Жавхланта сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тус цэцэрлэг нь тайлант онд сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 10,000.0 мянган төгрөгөөр зуны нүүдлийн цэцэрлэгийн барилгыг засварлаж, эцэг эх асран хамгаалагчдаас 850.0 мянган төгрөгийн телевизор үнэ төлбөргүй хүлээн авч, төсвийн хөрөнгөөр 4,160.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч тохижуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь

харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын 1 дүгээр цэцэрлэг нь тайлант онд 5 зорилтын хүрээнд 60 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээгээр 93.0 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БАТМӨНХ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

№	Данс-ны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	133,398,528.18	90,741,229.81
2	31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	79,486,349.24	30,620,279.87
3	31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	79,486,349.24	30,620,279.87
4	31210	Төгрөг	79,486,349.24	30,620,279.87
5	31211	Төрийн сангийн харилцах	79,486,349.24	30,620,279.87
6	35	БАРАА МАТЕРИАЛ	53,912,178.94	60,120,949.94
7	35400	Хангамжийн материал	53,912,178.94	60,120,949.94
8	35410	Бичиг хэргийн материал	59,500	240,500
9	35420	Аж ахуйн материал	41,014,499.94	47,985,299.94
10	35460	Хүнсний материал	1,223,419	280,390
11	35470	Бусад хангамжийн материал	11,614,760	11,614,760
12	2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	574,616,268.45	556,397,575.44
13	39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	574,616,268.45	556,397,575.44
14	39200	Биет хөрөнгө	573,396,268.45	555,177,575.44
15	39201	Барилга, байгууламж, орон сууц	581,226,396	591,226,396
16	39202	Хуримтлагдсан элэгдэл	-58,098,316.6	-72,876,679.35
17	39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	63,107,412.6	67,007,412.6
18	39206	Хуримтлагдсан элэгдэл	-47,403,905.76	-54,026,092.4
19	39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	27,233,495.5	28,343,495.5
20	39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,303,516.96	-24,233,128.94
21	39214	Бусад үндсэн хөрөнгө	87,188,253	87,188,253
22	39215	Хуримтлагдсан элэгдэл	-56,553,549.33	-67,452,080.97
23	39300	Биет бус хөрөнгө	1,220,000	1,220,000
24	39301	Програм хангамж	1,250,000	1,250,000
25	39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,250,000	-1,250,000
26	39303	Бусад биет бус хөрөнгө	1,220,000	1,220,000
27	3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	708,014,796.63	647,138,805.25
28	4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	500,000	3,000,000
29	41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	500,000	3,000,000
30	41300	Өглөг	500,000	3,000,000
31	41310	Ажилчидтай холбогдсон өглөг	500,000	3,000,000
32	5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	707,514,796.63	644,138,805.25
33	51	Засгийн газрын хувь оролцоо	707,514,796.63	644,138,805.25
34	51100	Засгийн газрын оруулсан капитал	99,492,449.14	99,492,449.14
35	511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	99,492,449.14	99,492,449.14
36	51200	Хуримтлагдсан үр дүн	602,303,773.9	538,927,782.52

37	51210	Өмнөх үеийн үр дүн	373,950,494.94	602,303,773.9
38	51220	Тайлант үеийн үр дүн	228,353,278.96	-63,375,991.38
39	51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,718,573.59	5,718,573.59
40	6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	708,014,796.63	647,138,805.25

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

№	Дансны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
1	I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	963,295,395.94	794,094,300
2	12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	260,332,995.94	794,094,300
3	120	Нийтлэг татварын бус орлого	260,332,995.94	20,962,000
4	120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	70,000	0
5	1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000	0
6	120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	232,454,996	10,850,000
7	120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	27,807,999.94	10,112,000
8	122	Тусламжийн орлого	0.0	773,132,300
9	1221	Хандив тусламж /дотоод/	0.0	773,132,300
10	12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	0.0	773,132,300
11	122111	Урсгал санхүүжилтийн орлого\	0.0	773,132,300
12	13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	702,962,400	0.0
13	1310	Улсын төвлөрсөн төсвөөс	702,962,400	0.0
14	131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	702,962,400	0.0
15	II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	734,942,116.98	857,470,291.38
16	21	УРСГАЛ ЗАРДАЛ	734,942,116.98	857,470,291.38
17	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	726,619,116.98	849,871,591.38
18	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	549,107,198.64	657,240,360.38
19	210101	Үндсэн цалин	320,319,530.16	442,099,302.51
20	210102	Нэмэгдэл	203,321,988.48	171,441,106.76
21	210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.0	16,570,000
22	210104	Урамшуулал	25,465,680	27,129,951.11
23	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,053,840.72	77,449,458.99
24	210201	Тэтгэврийн даатгалын зардал	43,673,686.89	53,801,002.51
25	210202	Тэтгэмжийн даатгалын зардал	5,758,247.35	6,060,382.84
26	210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	2,920,220.46	3,035,105.92
27	210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	2,741,795.93	2,741,034.68
28	210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	10,959,890.09	11,811,933.04
29	2105	Нормативт зардал	62,909,971	56,296,829

30	210502	Хоол, хүнс	62,909,971	56,296,829
31	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,676,800	1,789,100
32	210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,676,800	1,789,100
33	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,871,306.62	57,095,843.01
34	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,410,990	20,170,800
35	210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,298,010	3,696,350
36	210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,162,306.62	33,228,693.01
37	213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,323,000	7,598,700
38	2132	Бусад урсгал шилжүүлэг	8,323,000	7,598,700
39	213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,323,000	7,598,700
40	III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	228,353,278.96	-63,375,991.38
41	VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	228,353,278.96	-63,375,991.38

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

№	Данс-ны код	Дансны нэр, төрөл	1. Өмнөх он	2. Тайлант он
1	I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	703,032,400	773,132,300
2	12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	70,000	773,132,300
3	120	Нийтлэг татварын бус орлого	70,000	0
4	120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	70,000	0
5	1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000	0
6	122	Тусламжийн орлого	0.0	773,132,300
7	1221	Хандив тусламж /дотоод/	0.0	773,132,300
8	12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	0.0	773,132,300
9	122111	Урсгал санхүүжилтийн орлого\	0.0	773,132,300
10	13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	702,962,400	0.0
11	1310	Улсын төвлөрсөн төсвөөс	702,962,400	0.0
12	131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	702,962,400	0.0
13	II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	716,909,919.36	817,838,369.37
14	21	УРСГАЛ ЗАРДАЛ	716,909,919.36	817,838,369.37
15	210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	708,586,919.36	810,239,669.37
16	2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	548,607,198.64	654,740,360.38
17	210101	Үндсэн цалин	376,448,720.87	439,596,431.15
18	210102	Нэмэгдэл	146,755,879.59	171,441,106.76
19	210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.0	16,572,871.36
20	210104	Урамшуулал	25,402,598.18	27,129,951.11
21	2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,053,840.72	77,449,458.99
22	210201	Тэтгэврийн даатгалын зардал	47,128,153.8	53,801,002.51

23	210202	Тэтгэмжийн даатгалын зардал	4,566,701.26	6,060,382.84
24	210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	2,283,399.53	3,035,105.92
25	210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	2,283,400.53	2,741,034.68
26	210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	9,792,185.6	11,811,933.04
27	2105	Нормативт зардал	65,018,780	55,353,800
28	210502	Хоол, хүнс	65,018,780	55,353,800
29	2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,676,800	1,819,100
30	210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,676,800	1,819,100
31	2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,230,300	20,876,950
32	210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,681,600	16,452,600
33	210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,548,700	4,424,350
34	213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,323,000	7,598,700
35	2132	Бусад урсгал шилжүүлэг	8,323,000	7,598,700
36	213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,323,000	7,598,700
37	III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-13,877,519.36	-44,706,069.37
38	V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	0.0	4,160,000
39	22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	4,160,000
40	2200	Дотоод эх үүсвэрээр	0.0	4,160,000
41	225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.0	4,160,000
42	VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.0	-4,160,000
43	VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-13,877,519.36	-48,866,069.37
44	101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	93,363,868.6	79,486,349.24
45	20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	79,486,349.24	30,620,279.87

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Дансы код	Дансны нэр, төрөл	1. Устгалын өмнөх			
			Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	99,492,449.14	5,718,573.59	373,950,494.94	479,161,517.67
2	3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	99,492,449.14	5,718,573.59	373,950,494.94	479,161,517.67
3	9	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	228,353,278.96	228,353,278.96
4	10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	99,492,449.14	5,718,573.59	602,303,773.9	707,514,796.63
5	11	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	99,492,449.14	5,718,573.59	602,303,773.9	707,514,796.63

6	13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	99,492,449.14	5,718,573.59	602,303,773.9	707,514,796.63
7	19	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	-63,375,991.38	-63,375,991.38
8	20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	99,492,449.14	5,718,573.59	538,927,782.52	644,138,805.25

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан Улсын төсөв

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	779,617,400.00	773,132,300.00	6,485,100.00	99.2
12	Татварын бус орлого	779,617,400.00	773,132,300.00	6,485,100.00	99.2
122	Тусламжийн орлого	779,617,400.00	773,132,300.00	6,485,100.00	99.2
122005	Төсвөөс санхүүжих	779,617,400.00	773,132,300.00	6,485,100.00	99.2
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	853,880,700.00	821,998,369.37	31,882,330.63	96.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	853,880,700.00	821,998,369.37	31,882,330.63	96.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	846,282,000.00	814,399,669.37	31,882,330.63	96.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	676,215,600.00	654,740,360.38	21,475,239.62	96.8
210101	Үндсэн цалин	431,439,000.00	439,596,431.15	(8,157,431.15)	101.9
210102	Нэмэгдэл	211,758,200.00	171,441,106.76	40,317,093.24	81.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	16,572,871.36	(16,572,871.36)	
210104	Урамшуулал	33,018,400.00	27,129,951.11	5,888,448.89	82.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,776,700.00	77,449,458.99	6,327,241.01	92.4
210201	Тэтгэврийн даатгал	56,840,600.00	53,801,002.51	3,039,597.49	94.7
210202	Тэтгэмжийн даатгал	6,734,000.00	6,060,382.84	673,617.16	90.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,367,000.00	3,035,105.92	331,894.08	90.1
210204	Ажилгүйдлийн даатгал	3,367,000.00	2,741,034.68	625,965.32	81.4
210205	Эрүүл мэндийн даатгал	13,468,100.00	11,811,933.04	1,656,166.96	87.7
2105	Нормативт зардал	59,054,600.00	55,353,800.00	3,700,800.00	93.7
210502	Хоол, хүнс	59,054,600.00	55,353,800.00	3,700,800.00	93.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,103,900.00	1,819,100.00	284,800.00	86.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,103,900.00	1,819,100.00	284,800.00	86.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,131,200.00	25,036,950.00	94,250.00	99.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,706,800.00	20,612,600.00	94,200.00	99.5

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,424,400.00	4,424,350.00	50.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,598,700.00	7,598,700.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,598,700.00	7,598,700.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,598,700.00	7,598,700.00	-	100.0
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(74,263,300.00)	(48,866,069.37)	-	
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	74,263,300.00	48,866,069.37	-	
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	74,263,300.00	48,866,069.37	-	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	79,486,349.24		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	30,620,279.87	-	

## 2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан Орон нутгийн төсөв

/төгрөгөөр/

Данс-ны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	86,787,300	83,251,477.31	3,535,822.7	95.9
2	Татварын бус орлого	86,787,300	83,251,477.31	3,535,822.7	95.9
3	Нийтлэг татварын бус орлого	0	35,000	-35,000	
4	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	0	35,000	-35,000	
5	Тусламжийн орлого	86,787,300	83,251,477.31	3,535,822.7	95.8
6	Төсвөөс санхүүжих	86,787,300	83,251,477.31	3,535,822.7	95.8
7	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	86,787,300	83,251,477.31	3,535,822.7	94.5
8	УРСГАЛ ЗАРДАЛ	86,787,300	83,251,477.31	3,535,822.7	94.5
9	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	86,787,300	83,251,477.31	3,535,822.7	94.5
10	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	80,037,300	75,293,477.31	4,743,822.7	94.0
11	Гэрэл, цахилгаан	8,767,200	5,242,512.55	3,524,687.5	59.8
12	Түлш, халаалт	62,871,100	62,861,964.76	9,135.24	99.9
13	Цэвэр, бохир ус	8,399,000	7,189,000	1,210,000	85.5
14	Эд хогшил, урсгал засварын зардал	6,750,000	6,748,000	2000	99.9
15	Урсгал засвар	6,750,000	6,748,000	2000	99.9
16	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	0	1,210,000	0	
17	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0	-1,210,000	0	
18	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	0	-1,210,000	0	

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой **1,223.8** мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа. Үүнд:

- Байгууллагын ГҮ-ний урамшуулалаас суутгасан суутгалын 216.3 мянган төгрөгийг суутгагчийн хувь хүний таварын тайланд тайлагналгүй цалин, хөдөлмөрийн хөлс тэдгээртэй адилтгах орлогын тайланд тайлагнасан.
- Үндсэн хөрөнгийн хуримтлагдсэн элэгдэлийн эхний үлдэгдэл нь санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн элэгдлийн эхний үлдэгдлээс 1,007.5 төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн,

Дээрх алдаанууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалт болон УСНББОУС-17 “*Үндсэн хөрөнгө*”-ийн 13<sup>1</sup>, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “*Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам*”-ын 3.4, дахь заалтууд болон “*Үнэлгээ ба хуваарилалт*” батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Аудитаар нийт **60,918.9** мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 4,450.3 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 56,468.6 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгөв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 4,450.3 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 8,014.1 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага тул **Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.**

Commented [OA1]: Дүгнэлтийн үндэслэлийг тайлбарлах

#### 3.1 Албан шаардлага

**3.1.1.** Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр цалингийн тооцоололыг хянаагүйн улмаас 3000.0 мянган төгрөгийн цалингийн өр төлбөр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ” гэсэн заалтын дагуу нягтлан бодогч Б.Эрдэнэцэцэгт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

<sup>1</sup> Элэгдэл гэдэг нь хөрөнгийн элэгдүүлэх дүнг түүний ашиглалтын хугацааны туршид хуваарилах системтэй хуваарилалт юм, ашиглалтын хугацаа гэдэг нь а)байгууллагад уг хөрөнгө ашиглагдах боломжтой байхаар хүлээгдэж буй хугацаа,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**3.1.2** 2025 оны бүтэц орон тоонд батлагдаагүй бичиг хэргийн ажилтныг хавсран гүйцэтгэсэн гэх үндэслэлээр багш Б.Намжилсүрэнд 1,450.3 мянган төгрөгийн цалин олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, гэсэн заалт болон эрхлэгчийн 2025 оны 1-р сарын 03-ны өдрийн А/01 дүгээр “Бүтэц орон тоо” баталсан тушаалыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан орон тоо төсвийн дагуу ажиллах албан шаардлага хүргүүлэх.

### **3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Нормативт зардалтай холбоотой асуудал**

1.1 Илрүүлэлт: Хүүхдийн хоолны хүнсний материалыг олгохдоо насны ялгавартай нормативын дагуу тооцож олгоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2020 оны 12 сарын 2 өдрийн А/166 / А/559/ 222 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Цэцэрлэгийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах Хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”-г тогтоосон тушаалыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хүүхдийн хоолны хүнсний материалыг батлагдсан нормативын дагуу насны ялгавартайгаар тооцож олгох зөвлөмж хүргүүлээ.

#### **2. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал:**

2.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй тайлант оны эцэст ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа нийт 56,468.6 мянган төгрөгийн анхны үнэтэй 58 нэр төрлийн хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ТӨБЗГ-т ирүүлж шийдвэрлүүлнэ”, УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 13 (б)-д “Нэгээс дээш жил тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм” ХЗУ4-д “... байгууллага нь тухайн хөрөнгийг уг тайлангийн өдрөөр түүний одоогийн бодит үнэ цэнээр дахин үнэлэх

хэрэгтэй...” гэсэн заалтууд болон болон “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг тус тус хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох, актлах саналыг бэлтгэн, холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжүүдийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5<sup>3</sup> дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>3</sup> Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ГҮ-ний урамшуулалаас суутгасан суутгалыг суутгагчийн хувь хүний таварын тайланд тусгалгүй цалин, хөдөлмөрийн хөлс тэдгээртэй адилтгах орлогын тайланд тайлагнасан	1	216.3			1	216.3	1	216.3				
Үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэлийн эхний үлдэгдэл санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдлээс зөрүүтэй илэрхийлэгдсэн	1	1,007.5			1	1,007.5	1	1,007.5				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>1,223.8</b>			<b>2</b>	<b>1,223.8</b>	<b>2</b>	<b>1,223.8</b>				

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Батлагдаагүй орон тоог хавран гүйцэтгэсэн гэх үндэслэлээр цалин олгосон.	1	1,450.3			1	1,450.3						

